

Иргэний нийгмийн байгууллагад зориулсан “Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага” боловсруулах гэрээт зөвлөх (1-2 мэргэжилтэн) сонгон шалгаруулах зар

Төслийн танилцуулга

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академи (DWA)-тай хамтран “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг 2023-2026 онд хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудын ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Төслийн хоёрдугаар үе шат нь ИНБ-ууд, хэвлэл мэдээлэл, залуучууд зэрэг нийгмийн олон талт бүлгүүдийг төрийн бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах, эдгээр оролцогч талуудын үр дүнтэй харилцаа холбоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Энэхүү гарын авлага нь ИНБ-ууд цахим орчинд мэдээ мэдээллийг хүргэхдээ бусад оролцогч талуудын үнэт зүйл, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, зохисгүй үг хэллэгийг (үзэн ядсан, доромжилсон, ялгаварлан гадуурхсан гм) түгээн дэлгэрүүлэхгүй байх, нийгмийн тулгамдсан асуудал, олон нийтийн эрх ашгийг хөндсөн онцгой үйл явдлуудад өөрсдийн дуу хоолойг даацтай хүргэхэд баримтлах хэрэглэгдэхүүн болох юм. Улмаар ИНБ-уудад үр нөлөө бүхий мэдээлэл харилцааны бүтээгдэхүүнээр дамжуулан хүнлэг ёс, хүмүүнлэг иргэний нийгмийг цогцлооход хувь нэмэр оруулах чадамжийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр зорьж байна.

Зорилго

- ИНБ-уудын цахим орчинд мэдээлэл байршуулах, түгээхдээ баримтлах мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх;
- Цахим орчинд түгээсэн мэдээ мэдээллийн үр нөлөөний тухай ойлголт болон буруу ташаа мэдэгдэл, өдөөн хатгалтыг үл дэвэргэх, үүнийг засаж залруулах чадамжийг нэмэгдүүлэх;
- Цахим аюулгүй байдал төдийгүй цахим гэмт хэрэг, цахим халдлагад өртөхгүй байх, нягтлах, урьдчилан сэргийлэх ур чадвартай болох;
- Шинэ технологи, хиймэл оюун ухаанаас үүдэж болох ёс зүйн эрсдэл, түүнийг даван туулах арга замуудыг тодорхойлох;

Ажлын даалгаврын хамрах хүрээ

Гэрээт зөвлөх/зөвлөхүүд нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ИНБ-ын цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нөхцөл байдлын тандалт үнэлгээ хийх;
- Цахим орчинд хууль бус үйлдэл, хүний эрхийг хамгаалах чиглэлийн олон улсын стандарт жишгийг (Жишээлбэл: Global Network Initiative) судлах;
- ИНБ-уудад зориулсан “Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага”-ыг А4-ийн 30-40 нүүрт багтаан агуулга болон хэл найруулгын хувьд бүрэн боловсруулах, зөвлөмжид тулгуурлан засан сайжруулж хүлээлгэн өгөх;
- Иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулсан санал авах хоёр удаагийн уулзалтад оролцож гарын авлагыг танилцуулж саналыг тусгах;

Ажлын даалгавар гүйцэтгэх хугацаа 2025 оны 4-р сарын 30-наас 6-р сарын 25 хүртэл

Гэрээт зөвлөхөд тавигдах шаардлага, ур чадвар, туршлага:

- Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон цахим орчин дахь зөөлөн зохицуулалтын хэм хэмжээний талаар мэдлэг, практик туршлагатай байх;
- Олон талын эх үүсвэрээс мэдээлэл цуглуулах, судлан шинжлэх, дүн шинжилгээ хийх, найруулан бичих туршлага, ур чадвартай, шинэ санаачилгад нээлттэй;
- Ижил төрлийн удирдамж, гарын авлага боловсруулж байсан, хянан сайжруулж зөвлөмж өгч байсан бол давуу тал болно;
- Оролцогч талуудтай ярилцлага хийх, гарын авлагыг сайжруулах хэлэлцүүлгийг удирдан

- чиглүүлэх чадвартай;
- Цаг төлөвлөлт, харилцаа ба хандлага – Төслийн баг, оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллахад нээлттэй, үйл ажиллагааг төлөвлөгөөт хугацаанд бүрэн гүйцэтгэх;

Материал хүлээн авах:

Сонирхсон оролцогчид дараах мэдээллийг нэгтгэсэн PDF файлаар илгээнэ:

- Гарын авлагын агуулга, түүнийг боловсруулах цагийн хуваарь бүхий төлөвлөгөөг санал болгоно.
- Зөвлөх нь дангаар болон хамтран буюу 2 хүртэл хүнтэй баг болж өргөдөл гаргах боломжтой.
- Хувь хүний намтар (CV) эсвэл багийн танилцуулга (ижил төстэй удирдамж, гарын авлага боловсруулж хэлэлцүүлж хэвлэн нийтэлж байсан туршлагыг харуулсан байх);
- Өргөдөлд гэрээт ажилд ажлын хэдэн өдөр зарцуулах болон өдрийн ажлын хөлсийг тодорхой дурдана.

Материалуудыг нэгтгэн нэг PDF файлаар монгол болон англи хэлээр 2025 оны 4 дүгээр сарын 27-ны дотор дараах хаягаар илгээнэ үү:

Хэнд: Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

Гарчиг: Цахим орчинд мэдээлэл түгээх гарын авлага

И-мэйл: bolormaa@mediacouncil.mn

Төслийн зорилго: Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академи (DWA)-тай хамтран “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний Нийгмийн Байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг 2023-2026 онд хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд ИНБ-уудын ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгчдийн тухайд:

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулагдсан хэвлэмэл, цахим сайт, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага юм.

ХМЗ нь олон нийтийн сонирхолд үйлчилснээр хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийг мэргэжлийн сэтгүүлзүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд нь тусалдаг. Ингэхдээ бид Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй иргэн, хуулийн этгээдийн гомдлыг үнэ төлбөргүй бөгөөд шударгаар хэлэлцэж шийдвэр гаргадаг. Түүнчлэн ХМЗ нь хэвлэлийн эрх чөлөө, бие даасан ёс зүйтэй хэвлэл мэдээлэл, хариуцлагатай, ил тод ИНБ-уудыг чадавхжуулан бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах олон талт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Дойче Велле Академи (DW Akademie) нь ХБНГУ-ын Дойче Веллегийн олон улсын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүл зүйн сургалт, мэдлэгийн солилцооны төв юм. Дойче Велле Академийн төслүүд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэлд саадгүй хүрэх хүний эрхийг бэхжүүлэхэд чиглэдэг. Дойче Велле Академи нь дэлхийн эргэн тойронд хүмүүсийг найдвартай баримт, бүтээлч хэлэлцүүлэгт тулгуурлан бие даан шийдвэр гаргах чадвартай болгоход дэмжлэг үзүүлдэг. Дойче Велле Академи нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны стратегийн түнш бөгөөд Холбооны Гадаад хэргийн яам, Европын Холбооноос санхүүжилт авч, дэлхийн 70 орчим хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад идэвхтэй ажилладаг.